

## УЛААНБААТАР БРЭНД ЛОГО ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫ УДИРДАМЖ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1.1. Оршил

Дэлхийн бүх улс, хотууд сүлд тэмдэг ашигладаг бол аж ахуйн нэгж, компаниуд өөрсдийн гэсэн логотой байдаг. Сүлд тэмдгээр аль улсын ямар хот бэ гэдгийг таньдаг бол логогоор ямар компани бүтээгдэхүүн гэдгийг таньж мэддэг. Мэдээллийн технологийн эрин зууны хувьсгалыг даган дэлхийн томоохон хотууд өөрсдийн сүлд тэмдгээс гадна брэнд лого ашиглаж эхэллээ. Хотууд өөрсдийн брэнд лого бий болгож, тухайн хотын онцлогийг харуулсан брэнд, арга хэмжээнүүдэд ашиглаж байна. Зарим хотууд тухайн хотод үйлдвэрлэгдсэн бүх бараанд хотын брэнд логог байрлуулж, сурталчилж, түүгээрээ дамжуулан хотоо давхар сурталчилдаг маркетингийн шинэ аргыг хэрэгжүүлж байна. Брэнд лого ашиглаж сурталчилгаа хийх нь хотын эерэг имиджийг бий болгож, тухайн хотыг зорих жуулчдын урсгалыг бий болгодог байна. Монгол улсын Засгийн газраас 2020 он хүртэл Улаанбаатар хотын эерэг имиджийг бий болгож Зүүн хойд Азийн бүс нутгийн хэмжээнд эдийн засаг, аялал жуулчлалын тэргүүлэх хот болгох зорилт тавин ажиллаж байгаа билээ. Уг зорилтын хүрээнд “Улаанбаатар хотын брэнд лого шалгаруулах уралдаан”-ыг зарлаж, Улаанбаатар хотын шинэ брэнд логог бий болгохыг зорин ажиллаж байна.

#### 1.2. Үндэслэл

Энэхүү уралдааны удирдамжийг Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4.4 дэх “Улаанбаатар брэнд” бий болгох тухай заалтыг үндэслэн боловсруулав.

#### 1.3. Зорилго

Улаанбаатар хотын дүр төрхийг төлөөлж, хотын эерэг имидж бий болгох, хотын хөгжлийн чиг хандлага, иргэдийн хүсэл тэмүүллийг илэрхийлсэн олон төрлөөр ашиглаж болох брэнд логог шалгаруулж, цаашид логогоор дамжуулан Улаанбаатар хотыг сурталчлах брэндинг хийх

#### 1.4. Уралдааны хамрах хүрээ

- Монгол улсын харьяалалтай аж ахуйн нэгж, 16 нас хүрсэн хувь хүмүүс
- Монгол улсад бүртгэлтэй гадаадын аж ахуйн нэгж, Монгол улсад амьдарч буй гадаад улсын иргэд
- Гадаадад амьдарч буй Монгол Улсын иргэд

#### 1.5. Уралдааны хугацаа

Уралдааныг 2017 оны 08 дугаар сарын 29-ний өдрөөс 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл дөрвөн үе шаттай явуулна. /Уралдааны бүтээл хүлээж авах хугацааг 2.7 болон хамгийн сүүлийн хуудаснаас харна уу/

### 2. ХОЁР. УРАЛДААНЫ БҮТЭЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

#### 2.1. Бүтээлийн агуулга

Уралдаанд оролцож буй бүтээл нь утга агуулгын хувьд дараах шаардлагыг хангасан байна.

- ✓ Лого нь олон төрлөөр ашиглагдаж, брэндинг хөгжүүлэлт хийх боломжтой байна.

- ✓ Улаанбаатар хотын дүр төрхийг төлөөлөх дүрс, зурмалтай байна
- ✓ Логоны агуулга, зураглал нь хотын эерэг имиджийг бүрдүүлсэн байна.
- ✓ Логоны агуулгад хөгжлийн чиг хандлага, иргэдийн хүсэл тэмүүллийг илэрхийлсэн дүрс, билэгдэлтэй байна.
- ✓ Улаанбаатар хотын дахин давтагдашгүй онцлог, түүх, байгаль, монгол үндэсний уламжлалт хэв шинж, ахуй амьдралыг тусгасан байдлыг зөвшөөрнө.
- ✓ Хүний анхаарлыг эерэгээр шууд татах, өвөрмөц дизайн загвартай байж болно.

## 2.2. Бүтээлийн зурмалд тавигдах шаардлага

- Олон нийтэд ойлгомжтой, утга агуулга нь танигдахуйц байх
- Логог том жижиг олон хэлбэрээр ашиглах учир хэт нарийн зураас болон хэт жижиг дүрс ашиглахгүй байх
- Өнгөний хослолыг маш сайн гаргасан байх
- Зөвхөн компьютерт тусгай програм ашиглаж зурсан байх
- Логог агуулга концепци, утга билэгдэл, өнгөний код, самбар, сэтгүүл, нэрийн хуудас, хувцас, эд хэрэглэлд хэрхэн ашиглах, брэндиг хэрхэн хийх талаар дэлгэрэнгүй танилцуулсан 10-аас доошгүй хуудас брэндбүүктэй байна.

## 2.3. Зохиогчийн эрх

- Оролцогчийн зохиогчийн эрх нь оролцогч хувь хүн эсвэл албан байгууллагад байна.
- Уралдаанд ирүүлсэн бүтээлийг буцааж олгохгүй бөгөөд зохион байгуулагчдын архивд үлдэнэ.
- Шагналт байранд шалгараагүй бусад бүтээлийг бусад хувь хүн, байгууллагад худалдах, шилжүүлэх, хувиан олшруулах, бусад хэлбэрээр ашиглуулахгүй байх үүргийг санаачлагч, зохион байгуулагч тал бүрэн хариуцна.
- Шагналт байранд шалгарсан бүтээлийн зохиогчийн эрх нь зохион байгуулагч талд үлдэх ба цаашид зохион байгуулагч брэнд хөгжүүлэлт хийхийг, Нийслэлийн харьяаны бүх байгууллага ашиглахыг зохиогч зөвшөөрнө.
- Уралдаан дууссаны дараа шагналт байранд шалгарсан бүтээлийн зохиогчтой гэрээ хийж зохиогчийн эрхийг шилжүүлж авах бөгөөд зохиогчийн эрхийг зөвшөөрөөгүй бүтээлийг шагналт байранд шалгаруулахгүй, шалгарсан тохиолдолд шагналыг олгохоос татгалзаж, бусад бүтээлийг шалгаруулна.

## 2.4. Бүтээлийн хэмжээ

Уралдаанд ирүүлэх бүтээлүүдийг А4 форматтай бичгийн цаас болон зургийн зориулалтын цаасан дээр өнгөтөөр хэвлэх хэлбэр ирүүлнэ.

- Хэвлэмэл хуудас дээрх зургийн хэмжээ /Dimension/ хамгийн багадаа 600px X 600px буюу 6 см x 6 см түүнээс дээш, зургийн нягтаршил /Image Resolution/ 600 pixels x 600 pixels ба түүнээс дээш үзүүлэлттэй байна.
- Цаасан дээр шууд зурсан бол цаасан дээрх зурагны өндөр өргөн нь 6 см-ээс багагүй байна.
-

## 2.5. Бүтээлийн бусад шаардлага

- Уралдаанд нэг оролцогч хамгийн дээд тал нь 3 бүтээл ирүүлэх боломжтой.
- Бүтээл тус бүрт утга билэгдэл, зураглалын тайлбар, өнгөний код бүхий танилцуулгыг хавсаргаж ирүүлэх
- Оролцогч бүтээлд тус бүрт өөрийн нэр, холбоо барих утас, хаягыг тодорхой мэдээлсэн танилцуулга хуудас, анкетыг хавсаргасан байна.

## 2.6. Бүтээлд хориглох зүйлс

- Урлагийн хэт уран сэтгэмж, тодорхой танигдах дүрсгүй бүтээл ирүүлэхгүй байх
- Садар самууныг сурталчилсан утга билэгдэлтэй бүтээл ирүүлэхгүй байх
- Олонд танигдсан өргөн ашигладаг логотой төстэй бүтээл ирүүлж, шалгаруулалтын явцад хүндрэл учруулахгүй байх
- Зохиогчийн эрхтэй, бусдаас хуулбарласан, удирдамжид заасан шаардлагыг хангаагүй бүтээл ирүүлэхгүй байх

## 2.7. Бүтээл ирүүлэх

Уралдааны материалыг Нийслэлийн Аялал жуулчлалын газрын Мэдээлэл сурталчилгааны хэлтэст (Хаяг: Улаанбаатар хот, Бага тойруу-15, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Нийслэлийн Засаг захиргааны 4-р байр, 504 тоот) мэргэжилтэн А.Эрдэнэцогтод хэвлэмэл болон цахим хэлбэрээр ирүүлнэ.

**Уралдааны бүтээлийг 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17:00 цаг хүртэл хүлээж авна.**

- ✓ Хэвлэмэл хэлбэрийг бүтээлийн танилцуулга (2.4-д заасан шаардлагыг хангасан), оролцогчийг танилцуулгын хамт дээрх хаягийн дагуу хүргэж өгнө.
- ✓ Цахим хуулбар буюу брэндбүүкийг флаш диск болон [erdenetsogt@tourism.ub.gov.mn](mailto:erdenetsogt@tourism.ub.gov.mn) мэйлээр зураг, бүтээлийн эх файлыг зохион байгуулагчдад өгнө.
- ✓ Бүтээлийн эх файлыг JPEG, PNG өргөлттэй зургаар хүлээлгэн өгөхөөс гадна /.psd/, /.ai/ өргөлттэй задгай файлаар гэсэн хоёр төрлөөр бэлтгэн бэлэн болгосон байна. /.psd/ өргөлт нь Adobe Photoshop CS4 программ дээр, /.ai/ өргөлт нь Adobe Illustrator CS5 программ дээр нээгдэхээр тохируулсан байна)

## 3. ГУРАВ. ШАЛГАРУУЛАЛТ

### 3.1. Нэгдүгээр шатны шалгаруулалт:

Нийслэлийн аялал жуулчлалын газрын мэргэжилтэн удирдамжид заасан шалгаруулалтыг хангасан эсэхийг нягтлан шалгаж, материалыг хүлээж авах ба бүртгэж авсан бүтээлийг нэгдүгээр шатны шаардлагыг хангасан гэж үзнэ.

### 3.2. Хоёрдугаар шатны шалгаруулалт:

Зохион байгуулагчдын зүгээс томилсон шүүгчид үнэлгээ өгч, эхний 20 бүтээлийг олон нийтийн санал асуулгад оролцуулахаар нэр дэвшүүлнэ. Маркетинг, брэндбүк хөгжүүлэлтийн талаар мэдлэг туршлагатай мэргэжилтэн, салбарын төлөөлөл, зохион байгуулагч нарын төлөөлөл бүхий 5-7 хүнээс бүрдсэн шүүгчдийн баг оноо өгөх системээр үнэн зөвөөр шилдэг 20 бүтээлийг шалгаруулна.

### Оноог дараах байдлаар өгнө

Улаанбаатар хотын дүр төрхийг төлөөлөх дүрс зурмал орсон байдал	20 оноо
Логоны агуулга нь хотын эерэг имиджийг бүрдүүлсэн байдал	20 оноо
Улаанбаатар хотын дахин давтагдашгүй онцлогийг тусгасан байдал	20 оноо
Хүний анхаарлыг эерэгээр шууд татах	20 оноо
Өнгөний хослол, брэндбүүк хөгжүүлэлт хийсэн байдал	20 оноо
Бусад логотой төсөөтэй байдлыг оноогоор үнэлэх. Төсөөтэй бол оноо хасна	-20 оноо
<b>Нийт</b>	<b>100 оноо</b>

### 3.3. Гуравдугаар шатны шалгаруулалт:

Цахим хуудсаар дамжуулан санал авах бөгөөд хамгийн их хандалт авсан бүтээлд, шүүгчдийн оноог нэмж шилдэг бүтээлийг шалгаруулах бөгөөд шалгарсан бүтээлийг дөрөвдүгээр шатанд өрсөлдүүлнэ.

### 3.4. Дөрөвдүгээр шатны шалгаруулалт

Олон нийтийн санал асуулгаас эхний байранд шалгарсан 5 бүтээлийн Нийслэлийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шилдгийн шилдэг нэг бүтээлийг Улаанбаатар хотын брэнд логогоор шалгаруулж, олон нийтэд зарлаж алдаршуулна.

### 4. ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ

- Тэргүүн байранд нэг бүтээлийг шалгаруулж 5.000.000 /таван сая/ төгрөгөөр
- Дэд байранд нэг бүтээлийг шалгаруулж 3.000.000 /гурван сая/ төгрөгөөр
- Гутгаар байранд хоёр бүтээлийг шалгаруулж тус бүр 1.000.000 /нэг сая/ төгрөгөөр тус тус шагнаж, батламжилна.

### 5. МАРГААН ТАСЛАХ ЖУРАМ

- Оролцогч нар зөвхөн зохион байгуулагч нарт дараах асуудлын хүрээнд гомдол гаргаж болох бөгөөд үүнээс өөр асуудлаар гаргасан өргөдлийг хүлээн авч хэлэлцэхгүй.
  1. Зохиогчийн эрх зөрчигдсөн асуудлаар /Хүний бүтээлийг хулгайлж оролцсон, Шалгарсан бүтээл нь ямар нэгэн байгууллагын логотой ижил төсөөтэй,
  2. Шүүгчдийн бүрэлдэхүүнд оролцогчидтой ойр хамаатан бүхий хүн багтаж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл үүссэн үед
  3. Шүүгчид бүтээлүүдийг буруу шүүж шалгаруулсан.
- Гомдлыг 1 шатанд материал хүлээж авах хугацаа дуусахаас 2 цагийн өмнө, 2 шатанд шилдэг бүтээлийг шалгаруулж зарласнаас 1 цагийн дотор болон түүнээс өмнө, 3-р шатанд тэмцээний шагналт байрыг зарлаж, алдаршуулснаас 1 цагийн дотор тус тус хүлээж авна. 4 шатны шалгаруулалтад гомдол хүлээж авахгүй. Хугацаа хожимдсон гомдлыг хүлээж авахгүй.
- Гомдлыг бичгээр үйлдэж, гомдол гаргасан үндэслэлээ баталгаажуулж хавсаргасан байна. Үндэслэлээ батлаж хавсаргаагүй гомдлыг хүлээж авахгүйг анхаарна уу.

- Зохион байгуулагч тал гомдлыг хүлээн авч маш хурдан шийдвэрлэх бөгөөд хариу өгөх хугацааг гомдол гаргагчид урьдчилж мэдэгдэнэ.

УРАЛДААНЫГ САНААЧЛАГЧ, ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР

Дэлгэрэнгүй мэдээллийг 95193737 , 7014-8687 утсаар болон [www.facebook.com/UlaanbaatarTourism/](http://www.facebook.com/UlaanbaatarTourism/) фейсбүүк пейж хуудас болон [www.tourism.ub.gov.mn](http://www.tourism.ub.gov.mn) сайтаас авч болно.

Бүтээл хүлээж авах хаяг:

Хаяг: Улаанбаатар хот, Бага тойруу-15, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Нийслэлийн Засаг захиргааны 4-р байр, 504 тоот

***Бүтээл хүлээж авах эцсийн хугацаа: 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 17:00 цаг хүртэл***

--oOo--